



ЭРҮҮЛ МЭНДИЙН ХӨГЖЛИЙН ТӨВИЙН
ЕРӨНХИЙ ЗАХИРЛЫН ТУШААЛ

2017 оны 07 сарын 27 өдөр

Дугаар А/137

Улаанбаатар хот

Гадаад сургалтад хамруулах тухай

Эрүүл мэнд, спортын сайдын 2016 оны "Төгсөлтийн дараахь гадаад сургалтын тэргүүлэх чиглэл батлах тухай" А/169, Эрүүл мэндийн сайдын 2014 оны "Журам батлах тухай" 119 дүгээр тушаалаар батлагдсан "Эрүүл мэндийн ажилтанг гадаад оронд мэргэжлийн сургалтад хамруулах журам"-ын 3 дугаар зүйлийн 3.2 дахь заалт, Эрүүл мэндийн сайдын 2017 оны сургалтын хяналтын тоо, зардал батлах тухай" А/188 дугаар тушаалыг тус тус үндэслэн ТУШААХ нь:


1. БНЭУ-ын Фортис эрүүл мэндийн төвтэй байгуулсан гэрээний дагуу мэргэжил дээшлүүлэх сургалтад хамрагдах суралцагчдын нэрс, мэргэжлийн чиглэл, хугацааг хавсралтаар баталсугай.
2. Эрүүл мэндийн ажилтны мэргэжил дээшлүүлэх сургалтад шаардагдах зардлыг холбогдох зардлын зүйл ангиас тооцон гаргахыг Ахлах нягтлан бодогч /Д.Гантуяа/-д зөвшөөрсүгэй.
3. Сургалтын явцын тайланг сургалт эхэлснээс 7 хоногт багтаан бичгээр, төгсөлтийн тайланг суралцаж ирээд 7 хоногийн дотор, үр дүнгийн тайланг 3 дахь сард Эрүүл мэндийн ажилтны хөгжлийн алба /З.Наранбаатар/-нд, байгууллагын удирдлагад амаар болон бичгээр тайлагнахыг багийн ахлагчид тус тус үүрэг болгосугай.
4. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын баг /Ч.Баттулга/-т үүрэг болгосугай.

ЕРӨНХИЙ ЗАХИРЛЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН
ГҮЙЦЭТГЭГЧ Б.НАРАНТУЯА



420501

Ерөнхий захирлын 2017 оны 07 дугаар
сарын 27 ны өдрийн А/37 дугаар
тушаалын хавсралт



СУРАЛЦАГЧДЫН НЭРС, ХУГАЦАА

№	Овог	Нэр	Байгууллага	Хугацаа
1.	Нямсүрэн	Амаржаргал	Хөвсгөл, Нэгдсэн эмнэлэг	2017.08.14- 2017.09.12
2.	Очирсүх	Золзаяа	УХТЭ	2017.08.14- 2017.09.12